



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг дутуу, чанаргүй, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн зөрчлүүд байсаар байна.

Аудитын дүгнэлтээс, 2021 он

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

1. Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт
2. Аудитын ерөнхий дүн
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгүүд
4. Захиалагчийн саналд үндэслэсэн байдал
5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр эхлэх болон шилжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай төслүүд төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлт
7. Худалдан авах ажиллагаа
8. ТАХ-ний эрхийг шилжүүлсэн байдал, ХАА-ны төлөвлөгөө, үнэлсэн байдал
9. Захиалагч болон үнэлгээний хорооны үйл ажиллагаа
10. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, түүний чанар, чанарт өгсөн үнэлгээ
11. Захиалагч ба гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага
12. Санхүүжилт, гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт
13. Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтын хяналт
14. Хөрөнгө оруулалтын санхүүжилт
15. Аудитын дүгнэлт, зөвлөмж

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сумын VII баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р байр, 1, 2 давхарт

Утас: 7058-4203, 7058-4204

Цахим шуудан: dornod@audit.gov.mn
<http://audit.mn/>



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ



Орон нутгийн төсвөөр 2019-2020 онд Дорнод аймагт эрх шилжиж хэрэгжсэн төсөл, арга хэмжээ 3.0 тэрбум төгрөгөөр батлагдсан.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО




Боловсрол, соёл, урлаг, спорт, бусад салбарт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд түлхүү чиглэгдсэн.




Орон нутгийн 2020 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй 101.7 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ, 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй 112.7 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ байна.

ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



■ Нийт баталсан ■ Эрх шилжүүлсэн

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ





“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН



62

Аудитад орон нутгийн 2019-2020 оны төсөвт батлагдсан 62 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг хамруулав.

ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ



ГОЛ ЗӨРЧИЛ



Мөнгөн дүн:
1,967.8 сая төгрөг



ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГАА

ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ
ГҮЙЦЭТГЭЛ



- Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй буюу улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийгдсэн байна. /276.6 сая төгрөг/
- ТАХ-ний зураг, төсөл, ажлын даалгавар, газрын зөвшөөрлийг жагсаалт батлуулснаас хойш боловсруулж, батлуулсан байна. /1,098.5 сая төгрөг/
- Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна. /10.0 сая төгрөг/

- 2019 онд шинээр хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээг хуулийн хугацаанаас 8 хоногоор хоцроож холбогдох газарт эрх шилжүүлсэн байна.
- Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

- Зураг, төсөл хугацаандаа батлагдаагүй шалтгаанаар 2 ТАХ тайлант хугацаанд хэрэгжээгүй байна.
- Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг чанаргүй, дутуу, хугацаа хэтэрч гүйцэтгэсэн, ажил хүлээн авах комисс техникийн тодорхойлолтод бүрэн нийцээгүй автомашин хүлээн авсан зэрэг зөрчлүүд байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2019-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



- Төрийн байгууллагын 2 барилга /Хэрлэн сумын 10-р багийн барилга, Матад сумын багийн байр/
- Орон нутгийн өмчийн 3 барилга /Булган, Чойбалсан сум орон сууц, Чулуунхороот сумын халуун усны барилга/



- Барилгын өргөтгөл, бааз, төв байгуулах 5 газар /Халхгол сум Баянхошуу боомт МХГ-ын ажилчдын байр, Хэрлэн сум МСҮТ-ын бааз, Чулуунхороот ЗДТГ, боомт, Баян-Уул сум ахмадын байр/



- 7 орон сууцны дээврийн засвар /Хэрлэн, Халхгол сум/



- 3 Цагдаагийн хэсгийн засвар, тохижилт /Хэрлэн сумын 2-р баг, Дашбалбар, Баяндун сум/



- 19 газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Хэрлэн сум БОЭТ-ийн хүүхдийн тасаг, нөхөн сэргээх тасаг, Нийгмийн ЭМТ-д 2 удаа, ОНӨГ-т 2 удаа, МХГ-т 2 удаа, ГХБХБГ, ЗБОБГ, БТСГ, ХДТ, 17, 18-р цэцэрлэг, ХДТ, 4, 9, 17 дугаар цэцэрлэг, СХАА, Нутгийн захиргааны байгууллага, Багшийн хөгжил төв, Булган сумын СТ, авто зам, Хэрлэн сумын соёл урлагийн салбар г.м/



- Танхим, төв байгуулах 2 газарт /Дайчилгаа, Багш хөгжлийн төв/



- 13 газрын засвар, тохижилт /Татвар, УБХ, Баяндун “Угтам”, 5-р цэцэрлэг, ХДТ, Жуковын музей, БОЭТ, Буйр сургалтын бааз, Баян-Уул гал унтраах тав, Хэрлэн сумын Бэлтгэл үүрэгтний сургалтын төв гэх мэт.



- 2 газарт нисэх онгоцны буудал /Халхгол, Баяндун сум/



- 5 газрын халаалтын тогооны засвар /Хөлөнбуйр ЗДТГ, Булган сумын ЗДТГ, СТ, Баяндун ЕБС, Чойбалсан ЭМТ/



- 23 автомашин /Аймгийн ЗДТГ, ЦГ-3, БТСГ, Төрийн аудит, СХЗХ, МХГ-2, БОАЖГ, Татвар, ХХҮХ, ОБГ, ОНӨ 2, мал хулгайлах тасаг, сумд-7/



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2019-2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцээгүй байна.

Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг



БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАГДААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

№	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг /сая.төгрөг/
	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	
1	Угтамын рашаан сувиллыг орон нутгийн өмчид шилжүүлэх	20.0
2	Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн дадлагын бааз	60.0
3	Хувилах багаж, тоног төхөөрөмж /Орон нутгийн өмчийн газар/	6.5
4	Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллагад шаардлагатай тоног, төхөөрөмж	49.0
5	Нутгийн захиргааны 1, 2 дугаар байрны гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж	17.0
	Эдийг засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	
1	Угтамын рашаан сувиллыг орон нутгийн өмчид шилжүүлэх	20.0
2	Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн дадлагын бааз	60.0
3	Хувилах багаж, тоног төхөөрөмж /Орон нутгийн өмчийн газар/	6.5
4	Албан хэрэгцээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж /СХАА/	9.2
5	Нутгийн захиргааны 1, 2 дугаар байрны гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж	17.0

ЗАХИАЛАГЧИЙН САНАЛД ҮНДЭСЛЭСЭН БАЙДАЛ

Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 62 төсөл, арга хэмжээнээс 61 төсөл, арга хэмжээний саналыг орон нутгийн холбогдох төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

Харин “Нисэх онгоцны буудал барих” /Баяндун, Халхгол сум/ ажлыг ИНЕГ, аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчдийн саналыг үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ЭХЛЭХ БОЛОН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

2019-2020 ОНД
ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР
САНХҮҮЖҮҮЛЭХ

62
төсөл, арга
хэмжээ

88.7% Шинээр хэрэгжих
Төслийн тоо: **55**
Төсөвт өртөг: **2,494.2** тэрбум төгрөг

11.3% Шилжих
Төслийн тоо: **7**
Төсөвт өртөг: **501.8** сая төгрөг

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСЛИЙН ТОО



Өмнөх онтой харьцуулахад шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 2-оор нэмэгдэж, шилжих төсөл, арга хэмжээ 3-аар буурсан байна.

2019-2020 ОНД ӨМНӨХ ОНООС ШИЛЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС

№	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжиж эхэлсэн он	Хэрэгжиж дууссан он	Төсөвт өртөг (сая төгрөг)
	Нийтийн орон сууцны барилгын дээврийн засвар /Хэрлэн сумын 49а, 49б, 51, 52-р байр, Халхгол сумын 33, 36-р байр/	2018	2019	153.1
	Хэрлэн сумын 10-р багийн байрны барилга	2018	2019	90.0
	Сумын төвийн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх /Булган сум/	2018	2019	20.0
	Авто замын тэмдэг, тэмдэглэгээ хийх /Булган сум/	2018	2019	5.0
	Задгай тайз, хөгжим, техник хэрэгсэл худалдан авах /Аймгийн Хөгжимт драмын театр/	2019	2020	240.0




“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ТӨСЛҮҮД ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ



88.8%

2019-2020 онд шинээр эхлүүлэх зураг төсөв шаардлагатай 9 ТАХ байгаагаас нийт 8 ТАХ-ний /88.8 хувь/ зураг, төсөв нь орон нутгийн төсөв батлагдсанаас хойш баталгаажиж, хуулийн шаардлага хангаагүй байжээ.



20%

Хугацаандаа газрын зөвшөөрөл олгогдсон 1 төсөл, арга хэмжээ



80%

Жагсаалт батлагдсанаас хойш газрын зөвшөөрөл олгогдсон 4 төсөл, арга хэмжээ



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр 3 барилга /Хэрлэн сумын 10-р багийн байрны барилга, Матад сумын алслагдсан багийн төвийн барилга, Булган сумын орон нутгийн өмчийн орон сууц/ ашиглалтад оруулснаас 1 ТАХ-ний зургийн ажлын даалгавар хугацаа хоцорч, 2 ТАХ-нд зургийн ажлын даалгавар хийгдэлгүй зураг, төсөл боловсруулагдсан байна.

Орон нутгийн 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд нийт 5 ТАХ-нд 11,115.7 мянган төгрөгийг зураг, төслийн санхүүжилтэд олгохоос 10,163.7 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна. Үүнээс:

Төсөл, арга хэмжээний нэр	Хэтэрсэн хоног	Олгох санхүүжилт	Олгосон санхүүжилт (мян.төгрөг)
 Алслагдсан багт барилга барих /Матад сум/	135	3,500.0	2,555.0
 Хилийн хяналтын байцаагчдын орон сууцны өргөтгөл	14	500.0	493.0



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Шинээр хэрэгжих
62 төсөл, арга
хэмжээний гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах
худалдан авах
ажиллагааг зохион
байгуулсан арга

21%

Нээлттэй тендер шалгаруулалт

66%


Харьцуулалт

13%

Шууд гэрээ байгуулах

0%

Хязгаарлагдмал тендер шалгаруулалт



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ



100%

Засгийн газраас 2019 оны худалдан авах ажиллагааг бүрэн хэмжээнд цахим систем ашиглан зохион байгуулахыг даалгаж, хэрэгжилт 100 хувьтай байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАХ-НИЙ 28.0 ХУВИЙГ ХУГАЦАА ХОЦРООЖ ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН БАЙНА.




Журмын 2.11-д заасны дагуу 2019 оны төсөв батлагдсан 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс хойших хугацаагаар тооцон үзэхэд, эрхийг 2019 оны 02 сарын 03-ны өдөр хүртэл буюу 60 хоногийн дотор шилжүүлэхээр байсан байна.

Үүнээс 2020 оны ТАХ-г хуулийн хугацаанд нь шилжүүлж, 2019 онд шинээр хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2019.02.11-ний өдрийн А/74 дүгээр захирамжаар эрх шилжүүлсэн нь хуулийн хугацаанаас 8 хоногоор хоцроож журмын 2.13 дахь заалтыг зөрчсөн байна.


ТЕНДЕРИЙГ ЗАРЛАХДАА ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗААСАН ХУГАЦААГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас 8-203 хоногоор хойшилж тендер зарлагдсан 27 ТАХ, 2020 оны төлөвлөгөөнд тусгасан хугацаанаас 14-130 хоногоор хойшилж, тендер зарлагдсан 23 ТАХ-нүүд байна.

Төлөвлөгөөнөөс хэтэрсэн хоног
/2019/



Төлөвлөгөөнөөс хэтэрсэн хоног
/2020/





“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ЗУРАГ, ТӨСӨЛ ХУГАЦААНДАА БАТЛАГДААГҮЙ ШАЛТГААНААР 2 ТАХ ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.



2019 оны төсөл, арга хэмжээнүүдийн хувьд тендер нь төлөвлөгөөнд заасан хугацаанаас оройтож зарлагдсан ч тайлант хугацаанд хэрэгжиж дууссан байна.

2020 оны төсөл, арга хэмжээнүүдийн хувьд 21 нь тайлант хугацаандаа хэрэгжиж, 2 ТАХ тайлант хугацаанд хэрэгжээгүй байна. Зураг, төсөл хугацаандаа батлагдаагүйгээс “Төрийн албан хаагчдын орон сууцыг шинээр бий болгоход дэмжлэг” /Гурванзагал сум/, “Чингис хааны хар сүлдний тахилгын байгууламжийг барих ажлыг эхлүүлэх” /Булган сум/ ажлын тендер зохион байгуулагдсан ч оролцогч байхгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛААР СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.



2019-2020 онд ХАА зохион байгуулсан арга

№	ХАА-ны арга	2019	2020	Нийт
1	Цахим	31	26	57
2	Уламжлалт	1	4	5
	НИЙТ	32	30	62



Хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй байна.

ХАА-НЫ ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАЖ, ХУГАЦААНД НЬ ТАЙЛАГНАСАН БАЙНА.



ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, тайлагнасан эсэхийг үзэхэд орон нутгийн төсвийн 2019-2020 оны авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.5-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ЗАХИАЛАГЧ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ҮЙЛАЖИЛЛАГАА



Үнэлгээний хороог хугацаа
хоцорч байгуулсан төсөл,
арга хэмжээ

23

Хугацаа хоцорсон
дундаж хоног

62

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО БАЙГУУЛСАН ХУГАЦАА (хоног, төслийн тоо)

№	Он	Нийт ТАХ-ний тоо	Хэтэрсэн ТАХ-ний тоо	Хэтэрсэн дундаж хоног
1	2019	32	16	75.7
2	2020	30	7	49
3	НИЙТ	62	15	62

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС 2019-2020 ОНД 3-ААС ДЭЭШ АЖИЛ АВСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

№	Аж ахуйн нэгжийн нэр	2019 он			2020 он		
		Улсын төсөв /ТАХ-ний тоо/	ОН-ийн төсөв, ОНХС /ТАХ-ний тоо/	НИЙТ ТАХ-ний тоо	Улсын төсөв /ТАХ-ний тоо/	ОН-ийн төсөв, ОНХС /ТАХ-ний тоо/	НИЙТ ТАХ-ний тоо
1	“Бүжнэр” ХХК	2	2	4	1	3	4
2	“Донж өргөө” ХХК	3	1	4	2	2	4
3	“Ган октаэдр” ХХК	2	3	5	1	7	8
4	“Дорнод хийц” ХХК	1	2	3	1	8	9

Гэрээний
хэрэгжилтэд тавих
захиалагчийн болон
зохиогчийн хяналтыг
үр дүнтэй
хэрэгжүүлсэн байна.

- Зохиогчийн хяналтын зардлыг зураг, төсөв зохиогч хувь хүн, аж ахуйн нэгжид олгосон бол захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБГ-т олгосон нийт 18.7 сая төгрөгийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт төвлөрүүлж ажилласан байна.
- Захиалагч нь зураг төсөл зохиогч нартай Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн, 38.1.8 дахь заалтын дагуу зохиогчийн хяналтын гэрээ байгуулан үе шатны ажилбар бүрд хяналтыг хамтран хэрэгжүүлэн ажилласан байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ



2019-2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл (дунджаар)

100 %

ЧАНАРГҮЙ, ДУТУУ, ХУГАЦАА ХЭТЭРЧ ГҮЙЦЭТГЭСЭН, АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ КОМИСС ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТОД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ АВТОМАШИН ХҮЛЭЭН АВСАН ЗЭРЭГ ЗӨРЧЛҮҮД БАЙНА.

Дорнод аймагт 2019-2020 хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн ажлуудаас хугацаа хоцорч гүйцэтгэсэн 3 төсөл, арга хэмжээ байна.

ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНААС ХЭТЭРСЭН ХОНОГ, ААН

ТАХ-НИЙ НЭР	ХЭТЭРСЭН ХОНОГ	ТӨСӨВТ ӨРТӨГ
Соёлын төвийн халаалтын тогоо шинэчлэх /Булган сум/	4	8.0 сая төгрөг
Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт автомашин	4	17.8 сая төгрөг
Хүүхдийн тасагт УВЧ аппарат авах /БОЭТ/	41	5.4 сая төгрөг



ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНААС ХЭТЭРСЭН ШАЛТГААН

50.0%	ААН гэрээний хугацааг мөрдөөгүй.
38.8%	Цар тахалтай холбоотой.
11.2%	ААН давхар ажил гүйцэтгэсэн.





“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ГҮЙЦЭТГЭЛ ДУТУУ, ЧАНАРГҮЙ ХИЙГДСЭН АЖЛУУД



2019 оны оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт:



- ТАХ-ний нэр: Хилийн хяналтын байцаагчдын орон сууцны өргөтгөл /Баянхошуу боомт/
- Төсөвт өртөг: 41.0 сая төгрөг
- Гүйцэтгэгч: "Дорнын их өгөөж"
- Хэрэгжилт: Өргөтгөлийн барилгын ажил чанаргүй хийгдэж, дээвэр, цонх, хана, таазны хэсэгт эвдрэл, гэмтэл гарсныг гүйцэтгэгч компаниар дахин засварлуулсан боловч одоог хүртэл ашиглалтын шаардлага хангахгүй байна.



- ТАХ-ний нэр: "Угтам" рашаан, сувиллын гадна хашаа барих /Баяндун сум/
- Төсөвт өртөг: 10.0 сая төгрөг
- Гүйцэтгэгч: МСҮТ
- Хэрэгжилт: Хашааны хэмжээ нь 1,2м х 2,0м хэмжээтэй, 80 ширхэг байхаар ажлын тоо хэмжээнд тусгагдсан боловч хийгдсэн хашаа нь 0,75м х 2,0м хэмжээтэй 96 ширхэг хашаа хийгдсэн нь 48 м² хашаа дутуу хийгдсэн нь зураг, төслийн дагуу хийгдээгүй байна.



- ТАХ-ний нэр: Халуун усны барилгын засварт дэмжлэг /Чулуунхороот сум/
- Төсөвт өртөг: 70.0 сая төгрөг
- Гүйцэтгэгч: "Тэгш титан" ХХК

- Хэрэгжилт: Барилгын ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүсэж, дээвэр, хана, цонх, гадна фасад, дотор засал ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь чанаргүй хийгдсэнтэй холбоотой байна. Энэ талаар аймгийн МХГ-ын улсын байцаагчаас ашиглагч байгууллагад зөвлөмж өгөгдсөн байна.



- ТАХ-ний нэр: Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгох /Булган сум/
- Төсөвт өртөг: 79.0 сая төгрөг
- Гүйцэтгэгч: "ИГ" ХХК

- Хэрэгжилт: Өрөөнүүдийн тааз, дээврийн дулаалга чанаргүй хийгдсэнээс шалтгаалж 1 орон сууцны зочны өрөөний дээвэрээс салхи нэвтэрч, лампирэн тааз доош унасан байдалтай, үүдний өрөөний /тамбур/ хана, таазны доторлогоо хангалтгүй, зай завсартай байгаа нь чанаргүй хийгдсэнийг харуулж байна.



- ТАХ-ний нэр: Сумын сургуулийн хуучин дотуур байрыг орон нутгийн өмчийн орон сууц болгон засварлах /Чойбалсан сум/
- Төсөвт өртөг: 70.0 сая төгрөг
- Гүйцэтгэгч: "ИГ" ХХК

- Хэрэгжилт: Барилгын засварын ажил чанаргүй хийгдэж, коридорын өрөөний дулааны шугам хагарсан байдалтай, шал, хананы заслын ажил ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь чанаргүй хийгдсэнтэй холбоотой байна. Ашиглагч байгууллагаас гүйцэтгэгч байгууллагад хүсэлт тавьсан боловч одоог хүртэл дахин засварлаагүй байна.



- ТАХ нэр: Аймгийн БТСГ-ын хэрэгцээнд автомашин авах
- Төсөвт өртөг: 40.0 сая төгрөг
- Гүйцэтгэгч: "Мөнх орших баян" ХХК
- Хэрэгжилт: Аймгийн БТСГ-т нийлүүлэгдсэн Hyundai County маркийн дунд оёрын автобус нь техникийн тодорхойлолтод 25 хүний суудалтай, спидометр 150,000 км-ээс ихгүй гүйлттэй, 2018 оноос хойш импортлогдсон байх зэрэг шаардлагыг хангасан байхаар заасан байна. Гэтэл техникийн тодорхойлолтыг автомашинд нийцүүлэн дахин боловсруулж, комиссын гишүүдийн 2/5 нь тухайн автобусыг техникийн тодорхойлолтод бүрэн нийцэхгүй байна /өнгө үзмж, зориулалт/ гэсэн саналыг гаргаж байсан боловч олонхын саналаар хүлээн авсан байна.




“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ГҮЙЦЭТГЭЛ ДУТУУ, ЧАНАРГҮЙ ХИЙГДСЭН АЖЛУУД



2020 оны оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт:



ТАХ-ний нэр: Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын өргөтгөл, нэг цэгийн үйлчилгээний төв /Чулуунхороот сум/
Төсөвт өртөг: 83.3 сая төгрөг
Гүйцэтгэгч: “Тэргүүн констракшн” ХХК

Хэрэгжилт: Өргөтгөлийн барилгын дээрээс борооны ус дууссан, хананд цууралт үүссэн, хаалганы хүрээ салсан байдалтай байгаа нь чанаргүй хийгдсэнийг харуулж байна.

ТАХ-ний нэр: Сумын Засаг даргын Тамгын газарт авто машин /Гурванзагал сум/
Төсөвт өртөг: 45.0 сая төгрөг
Гүйцэтгэгч: “Батбилэг Гурван Эрдэнэ” ХХК



Хэрэгжилт: Гурванзагал сумын Засаг даргын Тамгын газарт нийлүүлэгдсэн Land Cruiser-100 маркийн авто машин нь техникийн тодорхойлолтод спидометрийн гүйлт 80,000 км-ээс ихгүй, 2012 оноос хойш импортоор оруулж ирсэн байх зэрэг шаардлагыг тавьсан байна. Гэтэл хүлээж авах үед спидометрийн заалтыг хүлээлцээгүй, 2021 оны 05 дугаар сарын байдлаар 120,000 км гүйлттэй байгаа нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагад бүрэн нийцэхгүй байна.



Дээрх барилга, байгууламж, засварын ажлууд ашиглалтын явцад асуудал үүсэж байгаа нь гүйцэтгэгч байгууллагын чанаргүй ажил гүйцэтгэсэнтэй холбоотой бөгөөд дахин засаж залруулах, дахин засварлах ажлыг чанаргүй гүйцэтгэсэн байгууллагуудад хариуцлага тооцох шаардлага үүссэн байна.

Мөн техникийн тодорхойлолтод бүрэн нийцээгүй автомашин нийлүүлэгдэж байгаа нь тендерийн үнэлгээ, хүлээж авах комиссын үйл ажиллагаатай холбоотой бөгөөд цаашид энэ талаар алдаа, зөрчил гаргахгүй байхад анхаарах шаардлагатай байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ЗАХИАЛАГЧ БА ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулах ажлын хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй дараах ажил байна. Үүнд:



- Мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх үйлдвэрлэлийн дадлагын бааз ажлыг “Дорнод хийц” ХХК гүйцэтгэж 2020.12.20-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. “Ковид-19” цар тахлаас шалтгаалан зөөврийн сууцыг газрын тосны 21 дүгээр талбайд байрлуулах, бохир, цэвэр ус, цахилгааныг гадна шугам сүлжээнд холбох ажлыг дулааны улиралд гүйцэтгүүлэхээр үүрэг даалгавар өгсөн байна.



Эдгээр ажлуудыг тайлант онд цаг хугацааны хувьд бүрэн дуусгах боломжгүй тул, санхүүжилт татуулахгүй байх зорилгоор, хугацаатай үүрэг, даалгавар өгч ажлыг хүлээн авдаг жишиг тогтсон байна.

ГҮЙЦЭТГЭГЧИД НЬ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.



Захиалагч ТАХ-ний санхүүжилтийг олгоходоо тухайн ажлын гүйцэтгэлийн баримт, захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт материал, ажлыг хүлээн авсан комиссын дүгнэлт зэргийг үндэслэж олгосон байна.

Аудитын явцад тайлант онд хэрэгжсэн ТАХ-ний ажлын гүйцэтгэл, түүний зураг төсөл зохиогч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт болон холбогдох бусад баримт материалаас үзэхэд ТАХ-ний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон гэдгийг харуулж байна.

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

Төсвөөс захиалагчийн хяналтын зардалд 110,7 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 22.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Зохиогчийн хяналтын зардлыг зураг, төсөв зохиогч хувь хүн, аж ахуйн нэгжид олгосон бол захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБ-ын газарт олгосныг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дансанд бүрэн төвлөрүүлж ажилласан байна.

Тус газраас хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын ажлын үр дүнг хангалттай гэж үнэлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд гарч байгаа зөрчил дутагдал нь захиалагчийн хяналтаас шалтгаалаагүй байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТ

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд нь үндэслэн бүрэн олгосон байна.



САНГИЙН ЯАМ

Аудитын хамрах хүрээнд 2019-2020 онд хэрэгжсэн 67 төсөл арга хэмжээний санхүүжилт хугацаандаа олгогдож, ажил нь хийгдсэн байна.

Дээрх журмын дагуу төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2019-2020 онд бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэхийг ярилцлагаар болон баримт материалтай тулган баталгаажуулахад журмын заалтын дагуу хэрэгжүүлсэн байна.

ЭРХ ШИЛЖСЭН 2020 ОНЫ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.



Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн эрсдэлийг бага гэж тооцсон тул дотоод хяналтыг хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”,

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ”

Тус алба нь 2018, 2019 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 3 дугаар саруудад дотоод хяналтыг хийсэн ч тайлан эцэслэн дуусаагүй хяналтын шатанд явагдаж байна.

Сүүлийн 3 жилд хийсэн манай аудитаас харахад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.





“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

БАРЬЦАА ХӨРӨНГӨ, УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГАА



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онуудад хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгогдоогүй байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАХ-НИЙ АШИГЛАЛТ



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд шинээр ашиглалтад орсон 10 барилга, байгууламж, 42 байгууллагад нийлүүлсэн тоног төхөөрөмжийг төсөвт байгууллагуудын эзэмшилд шилжүүлж, бүртгэл, тайланд тусган ашиглаж байна.



Хэрлэн сумын 10 дугаар баг, Матад сумын алслагдсан суманд багийн төвийн барилга, Баян-Уул суманд ахмадын байрны өргөтгөл, Чулуунхороот халуун усны газар, Булган, Чойбалсан сумдад орон нутгийн өмчийн орон сууцыг бий болгосноор төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хурдан шуурхай хүргэх, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн байна.



Чулуунхороот сумын Засаг даргын Тамгын газрын барилгын өргөтгөл, нэг цэгийн үйлчилгээний төв, Жуулчдад зориулсан мэдээллийн төвийг ашиглаж эхлээгүй нь “Ковид-19” цар тахлаас шалтгаалан доторх тохижилтын ажил хийгдээгүй байна.



Нисэх онгоцны буудал барих /Баяндун, Халхгол сум/ ажил дууссан ч ашиглаж эхлээгүй байна. Энэ нь зураг төсвийн дагуу агаарын хөлөг хөөрч, буух зурвас газрыг байгуулах, хашаажуулах ажил хийгдсэн ч хамгаалалтын зурвас, тэмдэг, тэмдэглэгээ, бусад нөхцөлүүд бүрэн бүрдээгүйтэй холбоотой байна.



“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2019-2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ЗӨРЧИЛ ШИЙДВЭРЛЭЛТ

Аудитаар нийт **1,967.8** сая төгрөгийн зөрчил илэрснээс **1,967.8** сая төгрөгийн зөрчил арилгах **6** албан шаардлага, **3** зөвлөмж өглөө.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.
- ХАА-г зохион байгуулахдаа төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримталж, тендерийн баримт бичгийн иж бүрэн байдлыг хангаж ажиллах.
- Ашиглалтгүй байгаа төсөл, арга хэмжээг цаашид ашиглалтад оруулах талаар холбогдох байгууллагуудад хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллах, хөрөнгийн үр өгөөжийг сайжруулах.